



Тоочин тайлбарлан бичих

Тоочин тайлбарлах

- **Тоочин тайлбарласан эх нь уншигчдад товч тодорхой мэдээлэл өгөхийг гол зорилгоо болгодог.**

Тухайлбал: газар орон, хүн амьтан , юм үзэгдлийн тухай мэдээлэл, шинжлэх ухааны ойлголтууд , сонины мэдээ, бараа бүтээгдэхүүний болон амралтаа яаж өнгөрөөсөн тухай, ном, киноны тухай мэдээлэл, зүг чигийн баримжаа олгох тайлбар, хоол хийх , цэцэг арчлах, шүдээ угаах тухай заавар зөвлөгөө гэх мэт тухайн сэдвийн хүрээнд уншигчид өгч буй бүхий л мэдээлэл тоочин тайлбарлан бичсэн эхэд орно.

Жишээ

“Шоргоолжны эх бие дундуураа тасархай юм шиг байдгийг та нар мэднэ шүү дээ. Тэр хоёр гэдсэнд нь яг тийм хэлбэртэй хоёр ходоод байдаг юм. Идсэн хоол тэжээл нь эхлээд хойд талын ходоодонд нь ордог байна. Үүр үүрлүүгээ явж байхдаа, өлссөн нэгэндээ урд талын ходоодноосоо хоол гарган тасалж өгдөг гэнэ.”

Зорилго нь шоргоолжны тухай тодорхой мэдээлэл өгөхөд оршиж байна.

Зоог тавих ёс

Мөч махыг зочинд тавьж өгөхдөө малын хөлийн газарт тулдаг чигийг зочин зүг харуулан таваглаж өгнө. Зочны өөдөөс богт чөмөгний нөгөө үзүүрээр харуулж тавибал “ Чамд заналтай” гэсэн дохио . Учир нь тэр үзүүр хөмхийгөө зууж буй мэт дүрстэй юм. Иймд зочинд богт чөмөг тавьж өгөхийг бүрэн цээрлэдэг. Хэрэв өгвөл дээрх хоёр дохионы аль нэг гэж ойлгодог байжээ. Мөн хүзүүг дангаар нь зочинд тавьж өгвөл” хүний хүн хүчгүй, хүзүүний мах амтгүй “ гэсэн дохио болно. Мөн богино хавиргыг айлчин зочинд тавьж өгдөггүй. Бас уураг сүүл, шагай чөмөгтэй хамт зочинд өгвөл тэр нь “Та бурхан” гэсэн дохио. Уул нь энэ хоёрыг “Бурхны хувь” гэдэг. Өвчүүний бүдэрхийг зочинд өгвөл “Унасан морь чинь бүдрэг” гэсэн дохио тул цээртэй. Хээрийн хүнд хонины дал, шаант, хавирга, сээр зэрэг мах талбих нь цээртэй. Өөрийн бөгөөд хүндтэй хүнд өгдөг зууш юм.

\ Л.Түдэв “Монгол дохио” \

- **Цээрлэх ёсны тухай талаар мэдээлж байгаа нь гол юм.**
- **Монголчуудын уламжлалт ёс заншлын тухай болох болохгүйн ялгааг тайлбарлан таниулахад оршиж байна.**

Тоочин тайлбарласан эх

- Тоочин тайлбарласан эх нь аливаа зүйлийн тухай уншигчдад тодорхой мэдээлэл өгөх зорилгыг агуулдаг. Өөрөөр хэлбэл элдэв баримтыг зохиогчийн хувийн дүгнэлтгүй, үйл явдлын болсон дэс дараа, бодит байдал, тоо баримтыг тэр хэвээр нь бичихийг хэлнэ.
- Тоочин тайлбарласан эхэд баримт чухал үүрэгтэй .
- Бодит амьдралд тохиолдсон үйл явдал, үзэгдэл юмс болон аливаа бүтээлд туссан таамаглал, дүгнэлт, тоон үзүүлэлт, тодорхойлолт, дэвшүүлсэн асуудал бүгд баримтын мэдээлэлд багтана.